

ХЯТАД МОНГОЛ ОРОС ГУРВАН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДУНДАХ ӨМӨЗО-Ы ХИЛИЙН БООМТЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

М.Бүрэнжаргал¹

Товч агуулга:

ӨМӨЗО нь Монгол болон Орос 2 гүрэнтэй 19-н боомтоор хиллэдэг. Тиймээс Хятад нь умарш нээлттэй улс юм. Тэр дундаа Манжуур, Эрээн хот, Ганц мод болон Цэгээ зэрэг 4 боомт бол Өвөр Монголоос Монгол болон Оростой эдийн засаг худалдаа арилжааны харилцаа хийх чухал боомтууд болно. Тус өгүүлэлд Хятад, Монгол, Орос гурван улсын эдийн засгийн харилцааны явц дахь ӨМӨЗО-ы хилийн боомтын хөгжлийн өнөөгийн байдал хийгээд тулгамдсан асуудалд задлан шинжилгээ хийгээд энэ тухай зарим санал зөвлөгөө өгсөн байна.

Түлхүүр үгс: ӨМӨЗО-ы хилийн боомт, Хятад Монгол Орос гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, санал зөвлөгөө

1 989 оноос Хятадын төр засаг Манжуур боомтийг анх нээснээс хойш ӨМӨЗО одоо нэгэнт усан зам, төмөр зам, агаарын тээвэр, засмал замын нийт 19 боомттой болжээ. Үүнд: Олон улсын чанартай үргэлжийн ба улирлын нээлттэй боомт, хоёр улсын чанартай үргэлжийн ба улирлын нээлттэй боомт, улсын ба орон нутгийн чанартай нээлттэй боомт багтана. Тэр дундаа Монгол улстай 10, ОХУ-тай 6 боомтоор хиллэж байна. Үүнээс гадна агаарын тээврийн боомт 3 байгаа бөгөөд эдгээр нь Хөх хот, Манжуур, Хайлаарын боомтууд болно. Төмөр замын боомт 2 байгаа бөгөөд энэ нь Манжуур ба Эрээн хотын боомтууд юм. Засмал замын боомт 13 байгаа бөгөөд эдгээр нь Манжуур, Эрээн, Ганц мод, Цэгээ, Зуун хатавч, Рашаан, Өвдөг, Торгуул, Ар хашаат, Хар дов, Шугуй, Мандал, Бага мод зэрэг болно. Усан

¹ М.Бүрэнжаргал- Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын сургуулийн багш, доктор (Ph.D).

замын боомт нэг байгаа бөгөөд энэ нь Хүрээтийн боомт юм. Энэ дундаас Торгуул, Бага мод, Хүрээт зэрэг 3 боомт нь хараахан нээгдээгүй байна.

Нэг. Өнөөгийн байдал

1. Боомтийн тээврийн ерөнхий чадвар гээшилжээ.

Холбогдох тоо баримтыг үндэслэвэл 2012 онд ӨМӨЗО-ы хилийн боомтоор дамжсан бараа таваар 67292.2 мян.тн бөгөөд энэ нь 1996 оныхоос 16 дахин ихэсч, 2000 оныхоос 8 дахин ихэссэн байна. 2012 оны хилийн боомтоор дамжин өнгөрсөн зорчигчдын тоо 4794.7 мян.хүн/удаа байсан нь 1996 оныхоос 5 дахин нэмэгдэж 2000 оныхоос бараг 3 дахин нэмэгдсэн байна.(хүснэгт 1). Тээвэрлэх чадварын өсөн нэмэгдсэн нь ӨМӨЗО-ы эдийн засгийн хөгжлийг ахиулснаар барахгүй Хятад Монгол хийгээд Хятад Оросын хоорондох эдийн засаг худалдааны харилцааг ахиулан хөгжүүлжээ.

Хүснэгт 1 ӨМӨЗО-ы хилийн боомтын ачаа тээвэрлэлтийн чадавхийн харьцуулалт

Он	Бараа тээвэрлэлтийн нийт тоо(/10.0 мян.тн)	Зорчигчидын тоо /10.0 мян. хүн.удаа/	Тээврийн хэрэгсэл /10.0 мян.цуваа. машин/	Худалдааны хэмжээ /10.0 мян. ам.доллар/
1996	414.41	90.09	18.72	124980
2000	814.29	155.01	28.36	203596
2011	6172.80	447.20	134.32	1293000
2012	6729.22	479.47	130.30	1125700

Тоо баримтын эх сурвалж: ӨМӨЗО-ны арилжааны танхимын веб сайт.

2011 онд ӨМӨЗО-ы хилийн боомтоор дамжсан нийт барааны хэмжээ 61728.0 мян.тн байж 2010 оныхоос 17.7 % аар өсчээ. 2011 оны боомт дамжсан худалдааны нэг онцлог нь Монгол улстай хийсэн боомтын худалдааны хэмжээ ихээр нэмэгдэж тухайн жилийн бараа тээврийн хэмжээ нь 32222.0 мян.тн байж өнгөрсөн оноосоо 22.9 хувиар нэмэгдэж ӨМӨЗО-ы хилийн боомтоор өнгөрсөн бүх тээврийн нийт хэмжээний 52.2 %-г эзэлж голдуу Ганц мод, Цэгээгийн боомтоор импортлосон нүүрс болон Эрээн хотын боомтоор

импортлосон төмрийн хүдэр модон материал болно.

2. Боомтын ачаалал нь голдуу дөрвөн их боомт дээр төвлөрчээ.

ӨМӨЗО-д байгаа 19-н хилийн боомтын хөгжлийн байдал болоод тээвэрлэх чадал нь ихээхэн зөрөөтэй. Хилийн нийт тээвэрлэлтийн 93.51-аас дээш хувь нь Манжуур, Эрээн хот, Ганц мод, Цэгээ боомт дээр төвлөрчээ. 2012 оноор жишээлэхэд эдгээр дөрвөн том боомтын бараа тээвэрлэлтийн нийт хэмжээ нь ӨМӨЗО-ы бүх хилийн боомтын бараа тээвэрлэлтийн нийт хэмжээний 97 хувийг эзэлж байна.

Манжуур хилийн боомтын бараа тээвэрлэлтийн хэмжээ нь хамгийн их боловч өсөлт нь тун удаан байна. Түүний шалтгаан нь 2010 оноос эхлээд Оросоос газрын тосыг газар доогуур хоолойгоор тээвэрлэх болсноос Манжуур боомтын бараа тээвэрлэлтийн хэмжээнд ихээр нөлөөлжээ. Ганц мод боомтын бараа тээвэрлэлтийн нийт хэмжээ 2006 онд 643 мян.тн байсан бөгөөд 2012 онд 12417 мян.тн болон өсч 2006 оныхоос 19 дахин нэмэгдсэн бол Цэгээ боомтын ачаа тээвэрлэлтийн нийт хэмжээ мөн 2006 онд 1539 мян.тн байснаа 2012 он болоход 9028 мян.тн болж өсөөд 2006 оныхоос 6 дахин нэмэгджээ. (хүснэгт 2). Энэ нь сүүлийн жилүүдэд Хятад, Монгол, Орос гурван улсын хоорондох тааламжтай байдлыг харуулж тэр дундаас Монголын уул уурхайн баялаг болох нүүрсний импортлол нь Хятад Монгол хоёр улсын хилийн худалдааны хэмжээг ихээр нэмэгдүүлжээ.

Хүснэгт 2. 2006, 2010, 2012 онуудад ӨМӨЗО-ы 4-н том хилийн боомтоор дамжин өнгөрсөн бараа бүтээгдхүүний тоо хэмжээ (10.0 мян.тн)

	2006			2010			2012		
	нийт	импорт	экспорт	нийт	импорт	экспорт	нийт	импорт	экспорт
Бараа бүтээгдхүүний нийт тоо	3365.6	3110.9	254.7	5238.1	4396.6	841.5	6309.3	4807.9	750.5
Манжуур	2165.7	2035.1	130.6	2611.3	2015	185.5	2815.6	1739.1	325.6
Эрээн	645.1	548.1	97	862.1	651.9	210.3	1160.4	826.6	333.8
Ганц мод	643.3	62.9	1.4	836.2	816.1	20.1	1241.7	1216.4	25.3
Цэгээ	153.9	153.7	0.2	865.9	861.8	4.1	902.8	872.5	30.3

Тоо баримтын эх сурвалж : ӨМӨЗО-ны арилжааны танхимын веб сайт. (2008 оноос хойших тоонд дамжин өнгөрсөн худалдааны тоо багтсан.)

2006 оноос хойш Хятадын төр засаг хийгээд ӨМӨЗО-оос хилийн боомтын дэд бүтэц болон хянан шалгах төхөөрөмжийн бүтээн байгуулалтанд нийт 47900 сая юаний хөрөнгө оруулалт хийжээ. 2012 онд Хятадын стратегийн зөвлөлөөс ӨМӨЗО-ы хилийн боомтын бүтээн байгуулалтанд зориулж 29000.0 мянган юаний хөрөнгө оруулж, ӨМӨЗО-ы стратегийн зөвлөлөөс 30000.0 мянган юаний хөрөнгө оруулж, ӨМӨЗО-ы санхүүгийн засаг захиргааны талаас хилийн боомтын бүтээн байгуулалтанд 70000.0 мянган юаний хөрөнгө оруулжээ. Олон талаас бүтээн байгуулалт хийснээс ӨМӨЗО-ы хилийн боомтын бараа тээвэрлэлтийн хэмжээ жил дараалан нэмэгдсэн байна. 2012 онд ӨМӨЗО-ы бүх хилийн боомтыг дамжсан бараа тээвэрлэлтийн хэмжээ 67292.0 мян.тн-д хүрчээ. Тэр дундаа Монгол болон Оростой хил дамжсан бараа тээвэрлэлтийн хэмжээ нь ӨМӨЗО-ы нийт хил дамжсан бараа тээвэрлэлтийн хэмжээний 97.8 хувийг эзэлжээ. Дээрх 4-н том хилийн боомтын бараа тээвэрлэлтийн нийлбэр нь 61205.0 мян.тн болж ӨМӨЗО-ы нийт хил дамжсан бараа тээвэрлэлтийн 91 хувийг эзэлжээ.¹ Бусад боомтоор дамжсан бараа тээвэрлэлтийн хэмжээ хэдийгээр бага байсан боловч жил дараалан өссөөр байжээ.

3. Хилийн боомтийн худалдаа хийгээд боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хөгжлийн шинэчлэл.

Холбогдох тоо бүртгэлийг үндэслэвэл 2011 онд ӨМӨЗО нь Монгол Орос хоёр улстай хийсэн импортийн хэмжээ 28930 сая ам.доллар , экспортийн хэмжээ 28450 сая ам.доллар байж, энэ нь ӨМӨЗО-ы бүх гадаад худалдааны 48.1 хувийг эзэлжээ. Хятадаас Монгол болоод Орост импортолж ба экспортлож байгаа худалдааны бүтэц нь дээшилжээ. 2011 онд Монгол болон ОХУ-д ӨМӨЗО-ы 19-н компани шинээр байгуулагдаж Хятадын талаас хөрөнгө оруулалтын гэрээний хэмжээ нь 6640 сая юаньбайжээ.² Эдгээр компаниуд нь голдуу уул уурхайн баялагийн хайгуул олборлолт, ой шугуйгаас мод бэлтгэх болон модон материалын боловсруулалт , барилгын ажил зэргийг эрхэлдэг. Хятад Монгол болон Хятад Оросын

хамтын ажиллагааны хэлбэр хүрээ нь тасралтгүй өргөжин тэлж байна.

ӨМӨЗО-ы дөрвөн том хилийн боомтын боловсруулах үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт ихээхэн амжилттай байна. Манжуурын импортлосон баялагийн боловсруулах үйлдвэрлэл нь голдуу модон материалыг боловсруулах аж үйлдвэрийн багцыг бүрэлдүүлсэн байна. Одоогийн байдлаар модон материалын компани 100 гаруй болж нийт 10000 гаран ажилтантай, 2011 онд 4612 мян.м³ модон материал боловсруулж, үйлдвэрлэлийн өртөг нь 63760 сая юань болжээ. Эрээн хотын боловсруулах үйлдвэрлэл нь БНХАУ-ын "ХI таван жилийн хугацаа"-нд нийт 76100 сая юань үйлдвэрлэлийн өртгийг бий болгож үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг нь 32800 сая юаньд хүрчээ. Ганц модны боловсруулах үйлдвэрлэлд 32 компанийг татан оруулж үйлдвэрлэлийн өртөг нь 112870 сая юань байж борлуулалтын орлого нь 110350 сая юань болжээ. Цэгээ боомт дахь арилжааны бүсийн бүтээн байгуулалт ид явагдаж байгаа бөгөөд түүхий нүүрс импортлох компанийн тоо 25-д хүрчээ.^[3] Хилийн боомт дахь худалдаа арилжааны гүйлгээ, хилийн боомтын аялал жуулчлал зэрэг орчин үеийн үйлчилгээний үйлдвэрлэл тогтвортой хөгжиж хилийн боомтын хотжилтын бүтээн байгуулалт хурдацтай хөгжиж байна.

Хоёр. Тулгамдсан асуудал

ӨМӨЗО-ы хилийн боомтын бүтээн байгуулалт ба хөгжүүлэлт амжилттай явагдаж хилийн боомтын эдийн засгийн үндсэн загвар бүрэлдсэн боловч хилийн боомтын ерөнхий хөгжлийн байдал нь тун муу, ӨМӨЗО-ы бүх хилийн боомт эдийн засгийн хөгжил тун тэнцвэргүй байна.

1. Боомтуудын хөгжлийн байдал нь тодорхой биш, харилцан өрсөлдөөн ихтэй.

Сүүлийн жилүүдэд ӨМӨЗО-ы хилийн боомтууд дахь аймаг, хот, хошууд нь идэвхтэйгээр боомтоо нээлтэй болгож хөрш орны байгалийн баялгийн импортийг нэмэгдүүлж байгаа боловч эдгээр боомтуудын ажиллагаа нь эмх замбараагүй байдалтай байна. ӨМӨЗО-ы хилийн боомтуудын хөгжлийн хэтийн байдал нь тодорхой биш байгаа нь хилийн боомтуудын эдийн засгийн хөгжлийг сааруулжээ. Манжуур болон

Эрээн хотын боомтуудын эдийн засгийн хөгжил нь нилээд төгөлдөржсөн боловч бусад боомтуудын эдийн засгийн хөгжил нь нилээд доогуур байдалтай байна.

ӨМӨЗО-ы боомтын хөгжилд бусад муж орны боомтын хөгжлийн өрсөлдөөн нөлөөлж байна. Жишээлбэл: Хар мөрөн муж болоод Шиньжяны уйгар үндэстний өөртөө засах орон зэрэг нь мөн л хилийн боомтын хөгжүүлэлтийн стратегийг хэрэгжүүлж байгаа нь ӨМӨЗО-ы Монгол болон Оростой хийж байгаа эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд нөлөө үзүүлж байна.

2. Хилийн боомтын чадавхи нь төгөлдөржөөгүй,
Хилийн боомт дагуу өөрийн гэсэн онцлогтой аж
үйлдвэрийн систем бүрэлдээгүй.

Хилийн боомтуудын ажиллагаа нь зөвхөн бараа өнгөрөөх зам төдий л байж хилийн боомтын эдийн засгийн хөгжил нь төгөлдөржөөгүй. Хилийн боомтын онцлогийг хадгалсан аж үйлдвэрийн систем бүрэлдээгүй, хилийн боомтын бараа түгээлтийн газрын бүтээн байгуулалт нь хоцронгуй байна. Хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутаг, хилийн дагуу суурьшиж байгаа иргэдийн хилийн худалдаа нь хөгжиж чадаагүй.

3. Хилийн боомтын менежмент муу, компаниуд нь
жигжиг байна.

Хилийн боомтын менежментийн газрын ажилтны тоо нь цөөхөн, эл салбарууд нь харилцан уялдаа холбоо муутай. Хилийн боомтын холбогдох ажиллагааны дүрэм боловсронгуй биш болохоор орон нутгийн засаг захиргаанаас боомтын ажиллагаанд зохистой арга авахад төвөгтэй байна.

Хилийн боомт дээрх түүхий эд материал боловсруулах арилжааны компаниуд нь жигжиг бөгөөд хөрөнгө оруулах чадвар буурай болохоор аж үйлдвэрийн хэлхээ бүрэлдэж чадахгүй. Компаниуд хувь хувиараа ажиллаж шударга бус өрсөлдөөнийг үүсгэх нь экспортийн эмх замбарааг алдуулж байна. Монгол ба Оростой хэлэлцээр хийхэд нэгдмэл үнэ ханшийн зарчим байхгүй байдгаас компаниудын худалдаалах өөрийн өртөг нь нэмэгдэж зах зээлийн үнийн хэлбэлзэл ба

арилжааны бодлогын нөлөөллийг хүртэх боломжийг улам их болгожээ.

4. Хөрш орнуудын төрийн бодлого нь тогтворгүй байна.

Монгол улсын төрийн бодлого хувирамтгай, валютийн ханшийн өөрчлөлт хувиралт их, засгийн газраас эдийн засагт зориулсан дүрэм журмын өөрчлөлт хувиралт их байгаа зэрэг нь Хятад Монгол 2 орны боомтын эдийн засгийн хөгжилд их хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Замаар гаргах ачааны хэмжээг хязгаарлах, тээврийн хэрэгслийг бөөгнөрүүлэн төвлөрүүлж байгаад шалгах, замын аюулгүй байдлын шалтгаанаар нүүрс тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хязгаарлах зэрэг Монголын талын дур зоригийн бодлого нь Хятадын компанид тун их хохирол үзүүлдэг.

Оросын эдийн засаг хэдийгээр сэргэж байна гэдэг ч эдийн засгийн явц дахь гүнзгий асуудлууд мөн л шийдвэрлэгдээгүй. Оросын алс дорнод бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн удаан дорой байгаа нь ӨМӨЗО болон Оросын хоорондох эдийн засгийн хамтын ажиллагаанд тасралтгүй шинэ асуудлуудыг тулгамдуулж буй.

Гурав. Санал зөвлөгөө

1. Хилийн боомтуудын чадавхийг зохистой байдалд оруулна.

Хилийн боомтыг хөгжүүлэхэд орон нутгийн бодит ахуйгаас үндэслэж шинжлэх ухаанчаар хөгжлийн байдлыг нь тогтооно. Дэс дараатайгаар хилийн боомтуудын нээлтэт чанарыг нь сайжруулж боомтын чадлыг төгөлдөржүүлнэ. Засмал зам, төмөр зам, агаарын тээврийн боомтын системийг бүрэн гүйцэд болгоно. Дөрвөн том хилийн боомтыг хөгжүүлэхээр суурь болгож ӨМӨЗО-ы зүүн талын бүс нутгийн хилийн боомтын ажиллагааны бүс ба баруун талын бүс нутгийн хилийн боомтын ажиллагааны бүсийг бий болгоно. Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг төгөлдөржүүлж хилийн боомтын ачаа тээвэр өнгөрөөх орчин тойрныг сайжруулж, хилийн боомтын менежментийг сайжруулан орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. Засгийн газраас хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж хилийн боомтын чадавхийг төгөлдөржүүлнэ.

2. Хилийн боомтуудын бараа тээвэр өнгөрүүлэх чадлыг сайжруулна.

Холбогдох нөхцлүүдийг хангасан хилийн боомтуудыг 24 цагаар ажиллуулж, хил давах хяналт шалгалтыг хялбарчилж зорчигчдын нааш цааш гарч хил нэвтрэхэд саад багатайгаар хурдан шуурхай хилийн боомтоор нэвтрэх нөхцлийг бүрдүүлнэ. Хилийн боомтын эдийн засгийн хөгжлийг бий болгох зорилгод нийцүүлсэн эл зүйлийн ажиллагааны дүрмийг бий болгоно. Интернет ба менежментийн шинэ арга эзэмшиж холбогдох тоо баримтыг нь интернетээр харилцан дамжуулж хилийн боомт болоод компаниудын ажиллагаанд ашиглуулж хангана. Хилийн боомтын гадаад нөхцлийг сайжруулж орчин үеийн технологийг ашиглах түвшнээ дээшлүүлж хилийн боомтын нэвтрэх түвшинг дээшлүүлнэ. Хилийн боомтын ачаа тээвэр, худалдаа, баримтын солилцоо, мөнгөний эргэлтийн мэдээний харилцааг шулуутгана.

3. Хилийн боомтууд дээрх хот сууринг хөгжүүлнэ.

Хил дагуу орон нутгийн хилийн нээлтийг улам гүнзгийрүүлж хил орчмын эдийн засгийг зах зээлийн эдийн засаг болгож хил дагуу хот суурины бүс нутгийг бүрэлдүүлнэ. Хятад ба хөрш орнуудын хоорондох эдийн засаг, нийгэм, соёлын харилцаа өдөр ирэхүйеэ нягт болж байгаа нь хил дагуу бүс нутгийн боомтын эдийн засгийн хөгжилд ихээр нөлөөлөх болжээ. Иймэрхүү нөхцөлд БНХАУ-ын баруун, дундад, зүүн талын бүс нутгийн хоорондох зах зээлийн харш саадыг багасгаж баруун бүс нутгийн хил дагуу зах зээлийг улам нээлттэй болгож хилийн боомтын эдийн засгийн хөгжилд ахицтай болгоно.

4. Хил дагуу өөрийн онцлогтой аж үйлдвэрийн багцыг хөгжүүлнэ.

ӨМӨЗО-ы хил дагуу орон нутгийн эдийн засаг болон орон нутгийн өөрийн онцлогт тулгуурлах аж үйлдвэрийг хөгжүүлнэ. Хил дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллага ба ард иргэдийн хилийн боомтын эдийн засгийн хөгжилд оролцох идэвхийг урамшуулна. Олон үе шаттай нээлттэй хамтын ажиллагааг өрнүүлж хил дагуу орон нутгийн хөгжил цэцэглэл ба аюулгүй байдал зэрэгт тохирсон орчин

үеийн шинэ өөрийн онцлог бүхий аж үйлдвэрийн багцыг байгуулан хөгжүүлнэ.

5. Хөрш орон хоорондын төрийн бодлогын уялдаа зохицлыг ахиулна.

Хөрш орнуудын хоорондох улс төрийн ойлголцол итгэлцээг гүнзгийрүүлж 2 талын засгийн газрын хоорондох холбогдох эдийн засаг, худалдаа, мөнгө санхүүгийн бодлогын тухай мэдээлэх ба зохицуулах ажиллагааг ахиулна. Үүгээр дамжиж хөрш орны хоорондох хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулна. Орчин үед дэлхий дахины эл орнуудын эдийн засгийн хөгжил нь хоорондоо нягт түшиглэх харилцаатай байдаг. Ямар нэгэн улсын эдийн засгийн бодлого нь нөгөө нэг хөрш орны хөгжилдөө нөлөөлөх боломж бий. Иймээс олон улсын хоорондох төрийн бодлогын уялдал зохицол нь өдөр ирэхүйеэ эл орны засгийн газрын хоорондох хамтын ажиллагааны чухал хэсэг болов. Хөрш орнуудын хоорондох харилцаа бол Хятадын гадаад харилцааны стратегийн суурь болно. Хөрш орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны харилцааг ахиулах бол БНХАУ-ын хөрш орны гадаад харилцааны төрийн бодлого ба стратегийг биелүүлэх чухал явц юм. Хөрш орнуудын удирдагчдын харилцан байнгын айлчлалын дунд 2 орны хоорондох хилийн боомтын хамтын ажиллагааны хөтөлбөрийн суурийг байгуулж улам бат бэх болгоно. Эдийн засгийн хөгжлөөр буурай орны байдлыг харгалзаж хамтын ажиллагааны байнгын тогтвортой байхыг хангана.

ЭШЛЭЛ

¹ ӨМӨЗО-ы Хөгжил шинэтгэлийн хорооноос гаргасан тоо баримт (内蒙古发展与改革委员会统计数据), 2013.11.03

²³ ӨМӨЗО-ы Худалдааны тэнхимийн хангасан тоо баримт (内蒙古商务厅统计数据), 2013.11.16

Ашигласан ном:

1. Ян Вэньлан/杨文兰, Ли Зиньлин/李金玲. “ӨМӨЗО-ы боомтын нээлтийн төлөв байдал” / “内蒙古口岸开放成效与不足分析” [J], Өвөр Монголын Санхүү Эдийн засгийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл/《内蒙古财经学院学报》2012 оны 6-р хэвлэл.

2. Жан Чанхун/张长虹. “ӨМӨЗО-ы хилийн боомтын бүтээн байгуулалт ба тулгамдсан асуудлын тухай” / “内蒙古口岸建设与存在问题分析” [J], Торгон сор сэтгүүл/《前沿》, 2005 оны 5-р хэвлэл.

3. Сю Хайцин/许海清. “ӨМӨЗО-ы боомтын эдийн засгийн хөгжлийн арга бодлогын тухай шинжлэл” / “内蒙古口岸经济发展对策研究” [D]. БНХАУ-ын Монгол улс судлах нийгэмлэгийн 2013 оны хурлын өгүүлэл. 2013.10 сар.

**A Research on the Developmental Problems of Inner
Mongolian Borders and Ports
in Economical Cooperation of Sino-Mongolia-Russia**

(School of Mongolian Studies, Inner Mongolia
University Huhkhote China)

Abstract:

Inner Mongolian Autonomous Region, which is an important front of Chinese opening-up to north, is bounded by Mongolia and Russia. It has 19 ports open to the outside world and from which Manjvvr, Ereenhot, Ganqimod and Sekhe are major ports to Mongolia and Russian. This article analyzes the existing problems and the current conditions of Inner Mongolian borders and ports in the process of Sino-Mongolia-Russia cooperation and suggests how to deal with them.

Key words: Inner Mongolian borders and ports, Economical cooperation of Sino-Mongolia-Russia, countermeasures